



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 481

Улаанбаатар хот

**“Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит
үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт,
зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг
батлах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Замын-Үүдийн дулааны станц” төрийн өмчит үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Үйлдвэрийн газрын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үндэслэн 2021 оны бизнес төлөвлөгөө, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, өр, авлагыг барагдуулах, худалдан авалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг захирал (У.Санрайжав)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 11 дугаар сарын 24 ны өдрийн
48- тогтоолын 1 дүгээр хавсралт

**“ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИН**

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2021 оны төлөвлөгөө
	Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, түгээлт, борлуулалт		
1	Дулаан үйлдвэрлэлт	мян.Гкал	37.5
2	Нийт орлого	мян.төг	1,736,060.0
	Үүнээс: Цэвэр борлуулалт	мян.төг	1,676,060.0
	Бусад орлого /алданги торгуулийн засвар үйлчилгээний орлогууд/	мян.төг	60,000.0
3	Нийт зардал	мян.төг	3,242,706.2
	Үүнээс: Удирдлагын зардал	мян.төг	58,563.8
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/	мян.төг	-1,506,646.1
5	Улсын төсвийн татаас	мян.төг	1,508,584.4
6	Цэвэр ашиг, алдагдал	мян.төг	1,938.2
7	Төсвийн төлбөрт нийт дүн	мян.төг	454,992.0
	а/ Орлогын татварт	мян.төг	0.0
	б/ НӨАТ	мян.төг	167,606.0
	в/ НДШ	мян.төг	128,200.8
	г/ ХАОАТатвар	мян.төг	82,710.2
	д/ Үл хөдлөх хөрөнгийн татвар	мян.төг	74,184.0
	е/ Тээврийн хэрэгслийн татвар	мян.төг	1,850.0
	ж/ Бусад татвар /Газрын төлбөрт/	мян.төг	441.0
8	Төрийн өмчийн ногдол ашигт	мян.төг	0.0
9	Нийт ажиллагсдын тоо	хүн	171.0
10	Нийт цалингийн сан	мян.төг	827,101.9
11	Нэг ажиллагчийн дундаж цалин	мян.төг	1,238.2
12	Нэгж бүтээгдэхүүний өртөг ДЭХ	төгрөг	86,523.7
13	Борлуулалтын 1 төгрөгт ногдох зардал	төгрөг	44,721.6
14	Хөрөнгө оруулалт	мян.төг	376,780.0
15	Нийт авлага	мян.төг	778,031.0
	Үүнээс: Найдваргүй	мян.төг	0.0
16	Нийт өглөг	мян.төг	3,268.2
	Үүнээс: Богино хугацаат	мян.төг	3,268.2
	Урт хугацаат	мян.төг	0.0

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 1 дугаар сарын 22-ны өдрийн
18/ тогтоолын 2 дугаар хавсралт

**“ЗАМЫН-ҮҮДИЙН ДУЛААНЫ СТАНЦ”
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН 2021 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үзүүлэлт	ТХ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Ажилчдын гал тогоонд тавилга, эд хогшил авах	1	18,200.0	18,200.0
2	Hyundai дунд оврийн автобус /2014 он/	1	45,000.0	45,000.0
3	Санхүүгийн программ /Unicus /	1	15,000.0	15,000.0
4	Оффесийн өрөөнд тавилга, эд хогшил авах	1	19,580.0	19,580.0
5	Ялтсан дулаан солилцуур 4мвт-4 ш	ш	12,250.0	49,000.0
6	Ялтсан дулаан солилцуур 5мвт-2 ш	ш	13,000.0	26,000.0
7	Өөрөө буулгагч	ш	60,000.0	60,000.0
8	Өөрөө буулгагч	ш	65,000.0	65,000.0
9	Дугуйт ачигч	ш	55,000.0	55,000.0
10	Дизель цахилгаан үүсгүүр 50-100квт	ш	10,000.0	10,000.0
11	120м3 усан сан	ш	14,000.0	14,000.0
	Дүн			376,780.0